

В ХЭСЭГ: СУУРЬ ҮНЭЛГЭЭ

БҮЛЭГ В8: ХҮН АМ БА ХҮН АМ ЗҮЙ

АГУУЛГА

8. ХҮН АМ БА ХҮН АМ ЗҮЙ	2
8.1 ТАНИЛЦУУЛГА	2
8.2 АРГА ЗҮЙ.....	2
8.3 ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ	3
8.3.1 Хүн ам ба хүн амын өсөлт.....	3
8.3.2 Хүн амын тархалт	4
8.3.3 Насны ангилал	5
8.3.4 Хүйсийн харьцаа	5
8.3.5 Угсаатан	5
8.3.6 Үндэстэн ястан	5
8.3.7 Хэл.....	6
8.3.8 Шашин шүтлэг	6
8.3.9 Боловсролын түвшин.....	6
8.3.10 Бичиг үсэг тайлагдсан байдал	8
8.4 ӨМНӨГОВЬ АЙМАГ	9
8.4.1 Хүн ам, хүн амын өсөлт	9
8.4.2 Насны ангилал	10
8.4.3 Хүйсийн харьцаа	10
8.4.4 Угсаатан зүй.....	10
8.4.5 Хэл.....	10
8.4.6 Шашин шүтлэг	10
8.4.7 Боловсрол.....	11
8.4.8 Бичиг үсэг тайлагдсан байдал	12
8.5 ХАНБОГД СУМ.....	12
8.5.1 Хүн ам, хүн амын өсөлт	12
8.5.2 Хүйсийн харьцаа	14
8.5.3 Угсаатан зүй.....	16
8.5.4 Хэл.....	16
8.5.5 Шашин шүтлэг	16
8.5.6 Боловсрол.....	16
8.5.7 Бичиг үсэгт тайлагдсан байдал	17
8.6 Төлөвлөж буй ажил	17

Зургийн жагсаалт

Зураг 8.1: Монгол улсын хүн амын тархац, 2009	4
Зураг 8.2: Бичиг үсэг тайлагдсан байдлын динамик үзүүлэлт, 2000-2009.....	8

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 8.1: Монгол улсын хүн амын зарим нэг чухал үзүүлэлтүүд.....	4
Хүснэгт 8.2: Монголын хүн амын тархан суурьшилт, 2003-2006	5
Хүснэгт 8.3: Монгол улсын боловсролын үзүүлэлтүүд	7
Хүснэгт 8.4: Сум болон аймгийн хүн ам.....	9
Хүснэгт 8.5: Өмнөговь аймгийн хүн ам, 2000, 2010 онуудад	10
Хүснэгт 8.6: Өмнөговь аймгийн хүн амын шашин шүтлэгийн байдал	11
Хүснэгт 8.7: Судалгаанд оролцогсдын боловсролын түвшин (%)	11
Хүснэгт 8.8: Ханбогд сумын хүн ам, 2007-2010	12
Хүснэгт 8.9: Хүн ам багийн зохион байгуулалтад хуваагдсан байдал	13
Хүснэгт 8.10: Орон нутгийн малчдын тоо ба Ханбогд сумын төвийн оршин суугчид, 2007-2010.....	13

8. ХҮН АМ БА ХҮН АМ ЗҮЙ

8.1 ТАНИЛЦУУЛГА

Тайлангийн энэхүү бүлэгт Оюу Толгой төсөл хэрэгжиж буй Монгол улс, Өмнөговь аймаг болон Ханбогд сумын хүн ам, хүн амын өсөлт, хүн ам зүйн бүтэц /насны бүрэлдэхүүн болон хүйсийн тэнцвэртэй байдал/ угсаатны аймаг, хэл, бичиг үсэгт тайлагдсан байдлын түвшин, боловсрол, шилжин суурьших хөдөлгөөн зэрэг хүн ам зүйн гол чухал үзүүлэлтүүд, тоо баримтуудын талаар дэлгэрэнгүй өгүүлэх болно.

8.2 АРГА ЗҮЙ

Мэдээллийн анхдагч эх сурвалж

Оюу Толгой нь төслийн нөлөөлөлд өртөх бүс нутгийн талаар суурь мэдээллийн нөхцлийг тодорхойлох зорилгоор өргөн хүрээний мэдээллийг цуглуулсан. Доор дурьдсан нэр бүхий судалгааны ажлуудын хүрээнд анхан шатны мэдээллийг цуглуулсан байна. Үүнд:

- Шилжин суурьших хөдөлгөөн болон шилжилтын чиг хандлагын талаарх мэдээллийг “Оюу Толгой төслийн хүн амын төвлөрлийн эрсдлийн үнэлгээ-2007” тайлангаас, төсөл хэрэгжих бүс нутгийн хүн ам, хүн ам зүйн нэмэлт мэдээллийг Азийн Хөгжлийн Банкны “Зүүн өмнийн говийн бүсийн хот суурин газар, хилийн хотхоныг хөгжүүлэх нь” болон “ТХХТ Төслийн Тайлангийн нэмэлт хавсралт А /2009/” зэрэг тайлангуудаас тус тус авч ашигласан;
- Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засаг, байгаль орчны (НЭЗБО) дэд судалгааг “Монгол улсын бодлого судлалын төв” болон “Хүн амын сургалт, судалгааны төв” хамтран хийж гүйцэтгэсэн ба энэхүү тайлан нь 2008 онд явуулсан Өмнөговь аймгийн Нийгэм эдийн засаг, байгаль орчны суурь судалгааны тайланд үндэслэсэн байна. Тус судалгаанд аймгийн айл өрхүүдийн 10% орчимыг төлөөлөхүйц 1,323 айл өрх хамрагдсан байна. Судалгааны тайланд Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогтцэций болон Даланзадгад сумдын үр дүнд анализ хийн аймгийн хэмжээний судалгааны үр дүнтэй харьцуулсан дүгнэлтийг оруулсан.
- Оюу Толгой ХХК нь мөн төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй Ханбогд сумын малчин өрх, хүн амын дунд нэмэлт хэд хэдэн судалгааг явуулсан. Үүнд:
 - 2007 онд Ханбогд сумын 280 малчин өрхийн дунд “Усны талаарх судалгаа” явуулсан бөгөөд энэ судалгаа нь усны хэрэглээ, усны чанартай холбоотой асуудлыг тодорхойлсны үндсэн дээр ирээдүйн чиг хандлагыг тодорхойлсон хамтын оролцоо бүхий усны менежментийн төлөвлөгөөг боловсруулах зорилготой байсан.
 - “Нүүлгэн суурьшуулсан малчдын үнэлгээ”-г Оюу Толгой ХХК -ний Олон нийттэй харилцах, тогтвортой хөгжлийн хэлтсээс /ОНХТХХ/ 2010 онд зохион байгуулсан. Үнэлгээний хүрээнд нөлөөлөлд өртсөн 16 малчин өрхийг хамруулж, нүүлгэн шилжүүлэх, нөхөн төлбөр олгох хөтөлбөр нь тэдэнд хэрхэн тусалж байгааг үнэлсэн бөгөөд цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн “Нүүлгэн суурьшуулах төлөвлөгөө”-г боловсруулсан. Энэ төлөвлөгөөний талаарх мэдээлэлтэй энэхүү тайлангийн D15 Бүлэгт дэлгэрэнгүй танилцана уу. Судалгааг малчин айл өрхүүдэд зочлон санал асуулгын хуудас бөглүүлэх байдлаар явуулсан.
 - 2011 оны 2-р сард төслийн нөлөөлөлд өртсөн байж болох малчин өрхийн судалгааг ОНХТХХ-ээс явуулж, өрхийн орлого, орлогын бүрдүүлэлт зэргийн талаарх мэдээллийг цуглуулсан байна. Судалгааны хүрээнд малчин өрхүүдэд зочлон хүн ам зүй, орлого, малын тоо толгой, өмч хөрөнгө, гэр бүлийн гишүүдийн байдал зэрэг чиглэлээр мэдээлэл цуглуулсан. Энэ судалгаа нь 2011 оны 5 сард шинэчлэгдэж, нөлөөлөлд өртсөн бүх малчин өрхийг хамруулсан бөгөөд улмаар төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй хүн амыг илүү тодорхой тогтоох боломжтой болсон.
- Монголын бэлчээрийн менежментийн нийгэмлэгээс Ханбогд суманд хэрэгжүүлсэн “Бэлчээрийн тогтвортой менежмент” төслийн тайланг 2010 онд гаргасан ба тайланд сумын бэлчээрийн нөхцөл байдал, Бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулагдаж буй явц, ахиц, сонгон авсан 2 багийн бэлчээр ашиглагчдын бүлэгт үзүүлсэн тусламж, дэмжлэгийн талаар тус тус судалгаа явуулсан

үр дүнгүүдийг багтаажээ. Тус нийгэмлэг нь тайланг улирал тутам шинэчилж байх бөгөөд сүүлийнх нь 2011 оны 1-р улирлыг хамарсан байх юм.

- Оюу Толгой ХХК нь сумын түвшний мэдээллийг цуглуулж *Ханбогд сумын Нийгмийн мэдээллийн санд (2011)* оруулсан бөгөөд энэ мэдээллийн санд сумын түвшний мэдээлэл тус бүрийг ангилан, эх үүсвэрийг тодорхой дурдаж эмхэтгэсэн тул сумын хэмжээнд хамгийн зохистой мэдээллийн лавлах болсон. Эдгээр мэдээллүүдийг Оюу Толгой төслийн БОНБНУ-ний тайлан болон төслийн суурь судалгааны мэдээллийг шинэчлэн боловсруулах болон шалгахад ашигласаар ирсэн юм.
- 2010 оны Монгол улсын хүн амын тооллогын урьдчилсан мэдээг энэхүү тайланд оруулсан ба Статистикийн Үндэсний Газар хүн амын тооллогын эцсийн дүнг 2011 оны 7 сард гаргасан байна.

Мэдээллийн хоёрдогч эх сурвалж

Мэдээллийг мөн Монгол улсын Эрүүл мэндийн яам, Үндэсний статистикийн газар зэрэг байгууллагуудын тайлан, хэвлэмэл материал, тоо баримтаас авсан бөгөөд ДЭМБ, Дэлхийн банк, НҮБ зэрэг байгууллагуудаас явуулсан үндэсний хэмжээний судалгааны үр дүнг нэмэлт болгон авсан.

8.3 ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

8.3.1 Хүн ам ба хүн амын өсөлт

Монгол улс нь 1.6 сая хавтгай дөрвөлжин км газар нутагтай ба энэ үзүүлэлтээрээ Ази тивдээ тавдугаар байрт ордог. Монгол улс нь хүн амын тооллогыг 1918, 1935, 1944, 1956, 1963, 1969, 1979, 1989, 2000, 2010 онуудад нийтдээ арван удаа явуулсан. Хамгийн сүүлд буюу 2010 оны 11-р сард хүн амын тооллого явагдсан ба аймгуудын хүн амын тооллогын урьдчилсан дүн мэдээ 2011 оны 7 сард гарчээ.

2010 оны тооцоогоор Монгол улс нь 2.9 сая хүн амтай, 1 хавтгай дөрвөлжин км газарт 1.7 хүн ноогдож байна (дэлхийд хүн амын нягтшил хамгийн багатай орон). Хүн амын өсөлтийн хэмжээ 1.5%¹ бөгөөд 2015 онд хүн ам нь 3 сая² хүрнэ гэж тооцоолж байна. Хүн амын дундаж наслалт 1992 онд 62.8 байсан бол 2008 онд 67.2 болтлоо өссөн боловч хүйсийн ялгаа анзаарагдаж байгаа (эмэгтэйчүүдийн дундаж нас 71.0, эрэгтэйчүүдийнх 63.7) юм. 2009 оны тоо баримтаас харахад насанд хүрэгчдийн дундаж наслалт нь 67.9 (эрэгтэй, эмэгтэй аль алинд) байна.

1980-аад оны сүүлчээр төрөх насны нэг эхэд ойролцоогоор 4.5 хүүхэд ноогдож байсан бол 1993 оны байдлаар 2.5 болж буурчээ. Улмаар 2000-2003 онуудад 2 хүүхэд болтлоо дахин буурсан байна. Харин 2003-2009 онуудад энэ үзүүлэлт 2.2 орчимд тогтвортой байсан юм. 1990-ээд оноос төрөлтийн хэмжээ ихээр буурсан хэдий ч хүн амын өсөлт тогтвортой хэвээр байна. Монгол улс шиг залуу хүн амтай ба өмнөх үеийн хүн амын хурдацтай өсөлттэй улсад хүн амын өсөлт буурсан эрчийг тогтворжуулж халахад нэгээс доошгүй үе дамжих хэрэгтэй болно³. Монгол улсын хүн амын 2000-2009 оны гол үзүүлэлтүүдийг Хүснэгт 8.1 үзүүлэв. Үүнд өсөн нэмэгдэж буй хүн амын хотжилт, төвлөрөлт ба төрөлтийн түвшин, 5-аас доош насны хүүхэд, эх, нярайн эндэгдэл зэрэг үзүүлэлтийн чиг хандлагыг харуулсан.

¹ Нэг эхэд ноогдох хүүхдийн дундаж тоо

² Ричардо Ф. Неуперт, 1996: Монгол улсын хүн ам ба нүүдлийн эдийн засаг, Ази номхон далайн хүн ам сэтгүүл. Боть 11, № 4, хуудас 27-46

³ www.hsph.harvard.edu/population/policies/mongolia.pop.doc

Хүснэгт 8.1: Монгол улсын хүн амын зарим нэг чухал үзүүлэлтүүд

Хүн ам зүйн үзүүлэлтүүд	2000	2009
Нийт хүн ам	2,407,500	2,735,500
Хот суурин газрын хүн ам %	57.2	62.6
Хүн амын өсөлт %	1.5	1.9
Цэвэр төрөлтийн түвшин /1000 хүн тутамд	21.5	25.3
Хүн амын дундаж наслалт	66.0	67.9
Нярайн эндэгдэл /1000 амьд төрөлт тутамд	31.2	20.2
5-аас доош насны хүүхдийн эндэгдэл/1000 амьд төрөлт тутамд	42.4	23.6
Эхийн эндэгдлийн түвшин/100,000 амьд төрөлт тутамд	158.5	81.4


Эх сурвалж: 2000, 2009 оны хүн амын тооллого. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, 2009 он (ЭМЯ, 2010 он).

1995 онд Монгол улсын Засгийн Газар улс орны хөгжил дэвшилд түлхэц болох үүднээс хүн амын өсөлтийг дэмжих бодлого боловсруулсан ба энэхүү бодлого нь 2010-2015 онд хүн амын дундаж өсөлтийг 1.8%-аас доошгүй хэмжээнд байлгах, нярай болон 5-аас доош насны хүүхдийн эндэгдлийг 1/3-ээр, эхийн эндэгдлийг 50 хувь хүртэл /1990 оны түвшнээс/ бууруулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх зэрэг зорилтыг дэвшүүлсэн байна.⁴

8.3.2 Хүн амын тархалт

2009 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын 62.6% (Зураг 8.1) нь хот суурин газарт, түүний талаас илүү хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байна (Хүснэгт 8.2). Хөдөө орон нутагт нэг хавтгай дөрвөлжин газар нутагт 0.65 хүн ноогдож байгаа нь дэндүү бага үзүүлэлт бөгөөд хүн ам маш сийрэг суурьшсаныг харуулж байна.

Зураг 8.1: Монгол улсын хүн амын тархац, 2009



Эх сурвалж: Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, 2009 он (ЭМЯ, 2010 он)

⁴ www.hsph.harvard.edu/population/policies/mongolia.pop.doc

Хүснэгт 8.2: Монголын хүн амын тархан суурьшилт, 2003-2006

Хүн ам	2003	2004	2005	2006
Нийт ('000)	2,504.0	2,533.1	2,562.4	2,594.8
Хот суурин газрын хүн ам	1,464.2	1,498.2	1,543.3	1,579.5
Үүнээс:				
Улаанбаатар хотын хүн ам	893.4	928.5	965.3	994.3
Хөдөөгийн хүн ам	1,039.8	1,034.9	1,019.1	1,015.3

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Газар

8.3.3 Насны ангилал

Монгол улсын хүн амын 27.6% нь 15-аас доош насныхан, 68,4% ийг 15-64 насныхан, 4%-ийг 65 болон түүнээс дээш насны хүмүүс эзлэж байна. Насны ангилалаар авч үзэхэд хүн амын 30,6% -ийг 15-29 насныхан, 2.02%-ийг 70-аас дээш насныхан тус тус эзэлж байна⁵.

Төрөлтийн хэмжээ өндөр байсан өмнөх үеийн залуужсан хүн ам нь өнөөгийн хүн амын өсөлтөд нөлөөлж байна. Төрөлтийн хэмжээ буурч байгаа болон дундаж наслалт нэмэгдсэн зэрэгт үндэслэн НҮБ-аас хүн амын өсөлт буурна гэсэн дүгнэлт гаргажээ. Хүн амын насны ангилалд аажмаар өөрчлөлт орж настай хүмүүсийн тоо зугуухнаар нэмэгдэх хандлагатай байна⁶. Монгол улсын хүн амын дундаж нас 1990 онд 19.3% байсан бол 2010 онд 25.4%-д хүрснээс үүнийг харж болно (Хүн амын дундаж нас 25 хүрэх нь хүн ам хөгширч буйг харуулдаг.)⁷

8.3.4 Хүйсийн харьцаа

Улсын хэмжээнд хүн амын 48.9%-ийг эрчүүд, 51.1%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь хүн амын хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй байгааг харуулж байна. Нийт өрхийн 11%-ийг эмэгтэйчүүд толгойлж байна.

8.3.5 Угсаатан

Монгол улсын хүн амын ихэнх нь Халх-Монгол үндэстэн бөгөөд Монгол хэлээр⁸ ярьдаг. Мөн тус улсад нилээд тооны орос, хятад иргэд амьдардаг. Харин Зөвлөлт Холбоот улс задран унасны дараагаар орос иргэдийн ихэнх нь нутаг руугаа буцсан байна⁹.

8.3.6 Үндэстэн ястан

Монгол улсын хойд хэсэгт байрлах Хөвсгөл нуурын орчимд Саяны нуруунд цаа буга маллан, Тува хэлээр ярьдаг 200 гаруй цаатан ястан амьдардаг. Мөн 300 гаруй Тунгус хэлээр ярьдаг Эвэнх буюу Монголоор бол Хамниган ястан өрх айл бас байдаг. Өмнөговьд угуул иргэд байхгүй. Гэсэн хэдий ч “угуул иргэд” гэдэгт нутгийн малчин иргэдийг оруулах эсэх талаар байнга маргаж байдгийг энд дурдах хэрэгтэй бөгөөд зарим гол хэлэлцүүлгийг дор дүгнэн бичэв.

“Дэлхийн улс орнуудын үндэсний цөөнх болон нутгийн уугуул иргэд” лавлах толинд (Олон улсын үндэстний цөөнхийн эрх-2010) Монголын нүүдэлчин, малчдыг үндэстний цөөнх, нутгийн уугуул

⁵ Нао Нукива-Монгол улсын хүн амын насны бүтцийг судлаж үзэх нь, Амьсгалын замын халдварын тухай Олон улсын симпозиум, 2009 он

⁶ НҮБ ын хүн амын сан: Монгол улсын хүн ам зүй

⁷ Монгол улсын засгийн газар, НҮБ Хүүхдийн сангийн хамтын ажиллагаа 2007-2011: дунд шатны тайлан

⁸ Дэлхийн улс орны цөөнх үндэстэн ба нутгийн уугуул иргэд лавлах толины 2007 оны хэвлэлд “ Монголын хүн амын 90 гаруй хувийг Халх монгол үндэстэн эзлэдэг бөгөөд 2000 оны статистикийн газрын тоо баримтаар тус улсын баруун хойд талд байрлах Баян-Өлгий аймагт голлон амьдардаг Казах үндэстэн 4 хувийг эзлэдэг гэсэн байна. Мөн Монгол улсад Дөрвөд, Буриад, Дарьганга гэсэн томоохон ястан амьдардаг. Казах үндэстэн дотор Түрэг язгуурын хэлээр ярьдаг Уйгар, Узбек, Хотон, Урианхай, Тува зэрэг ястангууд амьдардаг байна.

⁹ ОУ ын цөөнхийн эрхийг хамгаалах бүлэг, Дэлхийн улс орны цөөнх үндэстэн ба нутгийн уугуул иргэд лавлах толь-Монгол улс, 2007 он: www.unhcr.org/refword/docid/4954ce4bc.2010.11.12

иргэд гэсэн ангилалд оруулаагүй байна.¹⁰ Хэдийгээр гадаад ертөнцөд сайн танигдаагүй боловч Монголын нүүдэлчин малчид өөрсдийгөө нутгийн уугуул иргэд гэж үздэггүй юм. Малчин иргэдийн дунд өнөөгийн Монгол улсад тогтсон нийгмийн зохион байгуулалтын харилцаанаас өөр төрлийн зохион байгуулалт байдаггүй. Эцэг өвгөдийн газар нутаг, газар нутагтайгаа шүтэн баридлагатай ахуй амьдралын зохион байгуулалт нь нүүдэлчний хэв шинжийг агуулсан байх ба нь ихэнх Монголчуудын хувьд энгийн зүйл юм.

8.3.7 Хэл

Монгол хэл нь Урал-Алтайн язгуурын хэлний бүлэгт багтдаг. Монгол хэлээр (Монголын 2.8 сая хүн амаас хэд дахин илүү байна) 10 сая гаруй хүн ярьдаг. Монгол хэлээр яригсдын ихэнх нь Монгол улс, ОХУ-ын Буриад, Хятадын Өвөрмонгол, Шинжаан, Гансу муж, Төвд зэрэг газруудад амьдардаг. Монгол улсын баруун аймгуудад Түрэг-Монгол хэлний аялгуугаар ярьдаг хүн ам амьдардаг. Ойрадууд нь нутгийн аялгуугаар ярьдаг байна.

1921 оны ардын хувьсгалын дараагаар Монгол бичгийг¹¹ 1941 он хүртэл хэрэглэж байгаад албан ёсоор бага зэрэг өөрчлөлт оруулсан кирилл бичиг үсгийг хэрэглэх болсон байна. 1930-1940-өөд онуудад Ром цагаан толгойн үсгийг хэрэглэх оролдлого хэд хэдэн удаа хийгдсэн ч амжилтгүй болжээ. 1950-иад онд Кирилл бичигт шилжих явц бүрэн дуусч, 1950-иад оны сүүлчээр бичиг үсэг үл мэдэх явдал буурсан байна. 1990-ээд оноос Монгол бичгийн дахин сэргэлтийн үе эхэлж, дунд сургуулиудад зааж эхэлсэн ба одоо Монголын хүн амын бараг тэн хагас нь хуучин монгол бичгээр уншиж, бичиж чаддаг болжээ. Хэдийгээр кирилл үсгийг албан хэрэгт хэрэглэж байгаа ч хуучин монгол бичиг нь Монголын уламжлалыг харуулсан түүхэн бичиг үсэгт тооцогддог.

8.3.8 Шашин шүтлэг

Монгол улсад хамгийн өргөн дэлгэр шашин бол Төвдийн Буддын шашны Шарын урсгал юм. Буриадын “баруун хэсэг”, Дагуур, хуучин Барга, Дархад болон Хорь Буриадын нутагт уламжлалт бөө мөргөлийн зан үйл нилээн өргөн тархсан байна. Өнөөгийн байдлаар Монгол улсын хүн амын 5% нь Суннит (лалын шашны нэг урсгал) шашинтан ба гол төлөв баруун бүс нутгийн Казак иргэд байдаг. 1990-ээд оноос эхлэн Христийн шашинд итгэгчдийн тоо хэдэн арван мянгад хүрсэн ч Буддизм нь голлох шашин хэвээр үлдсэн юм.

8.3.9 Боловсролын түвшин

Дэлхийн банкнаас мэдээлснээр¹², Монгол улсын боловсролын салбар нь коммунизм нуран унаж, ЗХУ-аас боловсролын салбарт үзүүлэх тусламж зогсоод байсан үеэс уналтад орж байсан хэдий ч 1990-ээд оны эхэн үетэй харьцуулахад сэргэж байгаа юм. Сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газраас олон нийтийн боловсролд анхааран ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байгаагийн үр дүнд 1990-ээд оны үед өндөр үзүүлэлттэй байсан сургууль завсардалт буурч байна. Боловсролын салбар нь Монголын залуу үеийн бие бялдар, болон оюун ухааны хөгжлийг дэмжиж, бие дааж сурч, ажиллаж, амьдрах чадвартай болгоход чиглэгдэж байна¹³.

Боловсролын салбарт тулгамдаад буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол улсын Засгийн газар Дэлхийн банкны санхүүжилтээр “Хөдөөгийн Боловсрол-Хөгжлийг дэмжих” төсөл, “Бүх нийтийн боловсрол” зэрэг төслүүдийг тус тус хэрэгжүүлж байгаа юм. Эдгээр төслүүд нь хөдөө орон нутаг руу голчлон чиглэгдэж байна. Боловсролын гол үзүүлэлтүүдийг Хүснэгт 8.3-т харуулав¹⁴.

¹⁰ Үндэсний Цөөнх Иргэдийн Эрхийг Хамгаалах Олон Улсын Групп, Дэлхийн улс орнуудын үндэсний цөөнх болон нутгийн уугуул иргэдийн нөхцөл байдал 2010 – Монгол Улс, 2010 он 7 сар 1, <http://www.unhcr.org/refworld/docid/4c33310e3c.html> [2010 оны 11 сарын 12нд мэдээг авсан]

¹¹ Уламжлалт уйгаржин босоо бичиг

¹² Дэлхийн Банк, Хөгжлийн Сэдэв: Монгол улсын боловсролын салбарын нөхцөл байдал, 2007 оны 06 сар, <http://web.worldbank.org/>

¹³ Боловсролын салбарын хууль эрх зүйн асуудлууд, 2006 он

¹⁴ Дэлхийн Банк: Монгол улс: Ирээдүйн боловсролыг дэмжих нь, 2007 оны 07 сар <http://web.worldbank.org/>

Хүснэгт 8.3: Монгол улсын боловсролын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Он	Эзлэх хувь
Бага сургуулийн элсэлтийн түвшин (% цэвэр)	2009	90.5
Бага сургууль төгсөлтийн түвшин (% тухайн насны хүүхдийн тоотой харьцуулахад)	2008	93.3
Дунд сургуульд элсэлтийн түвшин (% цэвэр)	2009	82.4
Дээд сургуульд элсэлтийн түвшин (% нийт)	2009	52.7
Бичиг үсэгт тайлагдсан байдал (% 15-аас дээш насныхан дотор эзлэх хувь)	2009	97.5

Эх сурвалж: Дэлхийн банк

Монгол улсын боловсролын салбар нь хуучин Зөвлөлт холбоот улсын хэв загвар болох ясли, цэцэрлэг, 10 жилийн дунд сургууль, дээд сургууль гэсэн тогтолцоотой. Хичээлийн шинэ жил 9-р сарын 1-нд эхэлдэг. Дунд сургуульд элсэгчдийн түвшин улсын хэмжээнд өндөр буюу 90 гаруй хувьтай байна¹⁵. Бүрэн дунд боловсролын салбар нь 10 жилийн хөтөлбөртэй байсан. Монголын Засгийн Газраас боловсролын салбарт нилээд олон шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаагийн нэг нь дунд сургуулийг 11 жилийн сургалттай болгох явдал юм. Цаашдаа 12 жилийн сургалтын системд шилжих нэн тэргүүний зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна¹⁶.

2004 онд дунд сургуулийн 1-р ангид элсэн орж буй сурагчдын насыг 8-аас 7 нас болгон өөрчилсөн бол 2008 оноос 6 настайдаа сургуульд элсэн орох болсон. 2005-2008 онуудад 1-р ангиас 5 –р анги хүртэл тасралтгүй суралцагсдын түвшин (тууштай суралцаж байгаа үзүүлэлт) 88% орчимд тогтвортой байсан. Бага ангид элсэн суралцагсдын¹⁷ хүйсийн харьцаа 92.7% (2007 онд) байгаа нь тэнцвэртэй үзүүлэлт юм. Хүйсийн тэнцвэртэй харьцаа нь бага ангид тогтвортой байдаг ч ахлах анги, их дээд сургуульд элсэн орох үед эрс ялгаа гарч, эмэгтэй оюутнуудын тоо дийлэнх нь болдог байна. Их, дээд боловсролын сургуулиудад хүйсийн харьцаа 2005 оны байдлаар 1.53:1.00 (эм/эр) байсан. Үүний шалтгааныг эрчүүд нь голдуу мал аж ахуйд хөдөлмөр эрхэлдэг уламжлалтай холбоотой гэж үздэг.

Орлогын түвшин багатай бусад орнуудтай харьцуулахад Монгол орны боловсролын түвшин харьцангуй өндөр байдаг ч хот хөдөөгийн боловсролын түвшний ялгаа ихтэй. Хөдөө орон нутагт нилээд тооны хүүхдүүд бага, дунд боловсрол эзэмших боломжоор хязгаарлагдмал байсаар байна. ЮНЕСКО-ийн мэдээлснээр¹⁸ 2005 онд хөдөөгийн ихэнх дунд сургуулиудад элсэлтийн түвшин 80-аас доош хувьтай байж, сургуульд элсэх насны хүүхдүүдийн 20% нь сургууль завсардаж байсан байна. 2002 онд хийгдсэн Дэлхийн банкны Амьдралын түвшний судалгаагаар хөдөө орон нутгийн хүүхдийн 3% нь огт сургуульд суралцдаггүй, 95% нь 4-р анги төгсдөг, 9% нь 8-р анги төгсөхөөсөө өмнө сургуулиа орхидог гэсэн үр дүн гарсан байна. Хөдөө орон нутгаас хот руу шилжин суурьшигсдын тоо хэт нэмэгдсэнээр хотын сургуулиуд ачааллаа даахаа больсон байна¹⁹. Алслагдсан орон нутагт боловсрол эзэмших нь дараах хэдэн хүчин зүйлсийн нөлөөгөөр хязгаарлагдмал байсаар байна гэж үзэж байна. Үүнд:

- Хөдөө орон нутагт сургуулиудад олгох улсын төсөв хязгаарлагдмал, малчдын хүүхдэд зориулсан дотуур байранд халаалт, тоног төхөөрөмжийн хангалт хүрэлцээгүй байдаг.
- Монгол улсын хөдөө орон нутагт нүүдлийн мал аж ахуй нь малчдын амьжиргааны эх үүсвэр хэвээр байгаа тул ялангуяа хөвгүүд эцэг эхдээ туслахын тулд сургуулиас завсардаж, боловсролын үнэ цэнийг ойлгох үнэлэмж хангалттай бус байна. Бүрэн дунд сургуулийн ахлах ангид элсэгчдийн дөнгөж 40% нь хөвгүүд байна.

¹⁵ ДБ Нээлтэй мэдээллийн эх сурвалж: <http://data.worldbank.org/topics/education>

¹⁶ ДБ Нээлтэй мэдээллийн эх сурвалж: <http://data.worldbank.org/topics/education>

¹⁷ Элсэлтийн насыг харьяалах хүн амтай нь харьцуулан гаргадаг.

¹⁸ ЮНЕСКО Зайны сургалтаар бичиг үсэг тайлагдах нь: Монгол улс.; <http://www.unesco.org/uil/litbase/?menu=4&programme=51>


¹⁹ Дэлхийн Банк Хөгжлийн сэдэв: Монгол улсын боловсролын байдал, 2007.06 сар; <http://web.worldbank.org/>

- 16-аас доош насны бүх хүүхэд бүрэн дунд боловсрол эзэмших ёстой²⁰ гэсэн боловсролын хуулийн заалтыг ухуулан таниулах, орон нутгийн иргэдэд ойлгуулах ажил, үйлчилгээ хангалтгүй түвшинд байна.

8.3.10 Бичиг үсэг тайлагдсан байдал

Саяхан хийсэн судалгааны дүнгээс үзэхэд Зөвлөлт холбоот улсын задралтын үетэй харьцуулахад Монгол улсад бичиг үсэг тайлагдагсдыг тоо өссөн байгаа бөгөөд насанд хүрэгсдийн 97.8% нь бичиг үсэгт бүрэн тайлагджээ. /Зураг 8.2-г харна уу./ Бичиг үсэг тайлагдсан эмэгтэйчүүдийн тоо эрчүүдийнхээсээ бага зэрэг илүү байна²¹.

Зураг 8.2: Бичиг үсэг тайлагдсан байдлын динамик үзүүлэлт, 2000-2009



Эх сурвалж: CIA Дэлхийн лавлах²²

²⁰ ЮНЕСКО, Зайны сургалтаар бичиг үсэг тайлагдах нь: Монгол улс.

²¹ ОТ төслийн НЭЗБО-ны дэд судалгаа: Бодлого судлалын төв, Хүн амын сургалт, судалгааны төв, 2009 он

²² <http://indexmundi.com>

8.4 ӨМНӨГОВЬ АЙМАГ

8.4.1 Хүн ам, хүн амын өсөлт

2010 онд Өмнөговь аймгийн хүн ам 48,500 байсан нь аймгууд дундаа доороос 3-р байранд орох үзүүлэлт бөгөөд улсын нийт хүн амын 2 хүрэхгүй хувийг эзэлж байна²³. Тус аймгийн хүн амын гуравны нэг нь хот суурин газарт, үлдсэн нь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Нэг хавтгай дөрвөлжин газар нутагт 0.28 хүн ноогдож байгаа нь улсын хэмжээнд хамгийн бага үзүүлэлт юм.

1980-аад оноос эхлэн төрөлт буурч, төрөх насны нэг эхэд ноогдох хүүхдийн тоо 5-аар буурсан нь (8-аас 3 хүртэл) улсын хэмжээний энэ үзүүлэлтээс (6.3-аас 3 хүртэл буурсан) ихээхэн өндөр байна. Одоогийн байдлаар нэг эхэд ноогдох хүүхдийн тоо 2,08 байгаа нь улсын дундажтай ойролцоо үзүүлэлт юм.²⁴ Нэг эхэд ноогдох хүүхдийн тоо болон төрөлт буурсан гол шалтгаануудын нэг нь коммунизмын эрин үе төгссөнөөр хүмүүсийн амьдралын хэв маягт өөрчлөлт орж, цомхон гэр бүлтэй байх орчин үеийн хандлага зонхилж байгаа явдал юм.

2005-2007 онуудад эрчүүдийн дундаж наслалт нь 61.2%, эмэгтэйчүүдийнх 71.2% байсан ба 2010 онд дундаж наслалт 66.5% болж 2000 оныхоос (64.3) өссөн.

Аймгийн айл өрхийн дийлэнх нь 3-4 гишүүнтэй бөгөөд айл өрхийн 1 хүрэхгүй хувь нь түүнээс олон гишүүнтэй байна. Нэг гэр бүлийн гурван үе нэг дор хамтран амьдарч буй үзэгдэл түгээмэл байдаг байсан бол хотжилт, шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор буурч, гэр бүлийн уламжлалт бүтэц, гишүүдийн тоо өөрчлөгдсөөр байгаа юм. Ханбогд сум нь хөрш зэргэлдээ Баян-овоо, Манлай сумдаас илүү олон хүн амтай. Хүснэгт 8.4-г харна уу. Өмнөговь аймгийн төв Даланзадгад сум хамгийн их буюу ойролцоогоор 18,000 хүн амтай.

Хүснэгт 8.4: Сум болон аймгийн хүн ам

Он	Ханбогд (Оюу Толгойгоос 45км зайд байх гол суурин газар)	Баян-Овоо (Ойролцоох суурин газар, Оюу Толгойгоос 80км зайтай)	Манлай Ойролцоох суурин газар, Оюу Толгойгоос 120км зайтай)	Даланзадгад (аймгийн төв)	Нийт аймгийн хэмжээгээр
Нийт хүн ам, 2007 онд	2,974	1,539	2,510	15,176	47,299
Нийт хүн ам, 2010 онд	3,522	1,600	2,441	18,746	48,517
Хүн амын өсөлтийн түвшин 2006-2007 онд	2.5	1.3	1.6	3.1	2.1
% Хөдөөгийн хүн ам	59.7	74.5	79.6	3.1%	
% Өрх толгойлсон эмэгтэйчүүд	18.3	17.4	21.9	22.1	20.0
Хүн амын нягтаршил км ²	0.2	0.15	0.2	31.9	0.28

Эх сурвалж: 2007, 2010: 2007, 2010: Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс, 2010.

Ханбогд сумын Засаг Даргын Тамгын газар, Эрүүл мэндийн үнэлгээ, 2010. Үндэсний Статистикийн Газрын хүн амын тооллогын тоо баримт.

2000 болон 2010 оны Өмнөговь аймгийн хүн ам зүйн гол тоон үзүүлэлтүүдийг Хүснэгт 8.5-д харуулав. Эдгээр тоо баримтууд тус улсын хэмжээнд хүн ам өсч, хөгширч байгаа ерөнхий хандлагуудыг мөн тусган үзүүлсэн.

²³ Аймаг сумын засаг даргын тамгын газар нь иргэдийн бүртгэл дээр үндэслэн тооцоо, тооллого хийх шаардлагатай гэдгийг онцлон тэмдэглэж байна.

²⁴ Монголын Үндэсний Статистикийн Газар, 2003: 20-р зууны Монголын хүн ам хэвлэл, Улаанбаатар, Үндэсний Статистикийн Газар, хуудас 185-188

Хүснэгт 8.5: Өмнөговь аймгийн хүн ам, 2000, 2010 онууд

Гол үзүүлэлтүүд	Өмнөговь, 2000	Өмнөговь, 2010
Нийт хүн ам	45,420	48,517
Хүйсийн харьцаа /эм/эр/	49.6/50.4	49.1/50.9
Насны бүтэц (%)		
0-14 нас	40.3	30.0
15-64 нас	54.9	64.9
65+ нас	4.8	5.1
Дундаж нас	18.5	23.3
Дундаж наслалт	64.3	66.5

Эх сурвалж: Оюу Толгой ХХК, Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын үнэлгээ, 2011 он.

8.4.2 Насны ангилал

2010 оны байдлаар Өмнөговь аймгийн хүн амын 30%-ийг 0-14 насны, 64.9%-ийг 15-64 насны, 5.1%-ийг 65-аас дээш насны иргэд тус тус эзэлж байна. Улсын хэмжээнд эдгээр үзүүлэлтүүд нь тус бүр 27,6%, 68.4%, 4%-тай байдаг.

8.4.3 Хүйсийн харьцаа

Тус аймгийн хэмжээнд 2010 байдлаар хүйсийн харьцаа 49.1% /эр/ болон 50.9% /эм/ байгаа нь тэнцвэртэй байдлыг харуулж байна. Аймгийн нийт өрхийн 20% нь өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй байдаг бол улсын хэмжээнд энэ үзүүлэлт ердөө л 11%-тай байдаг.

8.4.4 Угсаатан зүй

2000 оны хүн амын тооллогын дүнгээс үзэхэд Өмнөговь аймгийн хүн амын 99.87% нь Халх-Монголчууд, ердөө 0.13%-ийг нь л бусад үндэстэн ястнууд эзэлж байна. Өмнөговь аймагт хийгдсэн суурь судалгаанд оролцсон иргэдийн олонхи нь хэдийгээр зарим үндэсний цөөнх байдаг ч гэсэн халх ба монгол гэсэн нэршлүүд нь адил утгатай гэж хариулсан байна²⁵. Асуулгад оролцогсдын тал хувь малчид байсан ба өөрсдийгөө үндэсний цөөнх гэхээс илүү монгол үндэстэн гэж үздэг ажээ.

Тус аймагт Дөрвөд, Торгууд, Урианхай, Захчин, Өөлд зэрэг яс үндэстэй 117 хүн 1989 онд бүртгэгдсэн байсан боловч 2000 онд 63 болтлоо буурсан байна. Энэ нь Зөвлөлт засаглалын үед хориотой байсан хүн амын шилжилт хөдөлгөөний дүрэм журам суларсантай холбоотойгоор үндэсний цөөнх иргэд төрөлх нутагтаа эргэн очих боломжтой болсноос шалтгаалсан байх магадлалтай.

8.4.5 Хэл

Өмнөговь аймгийн хүн ам Халх монгол хэлээр ярьдаг. Суурь судалгааны үр дүнгээс харахад төслийн бүст бичиг үсэгт тайлагдсан иргэдийн 29.2% нь хуучин монгол бичгийг сайн мэддэг байна. Гэхдээ хуучин монгол бичгийг мэддэг иргэдийн тоо сум сумдаар ялгаатай байна.

8.4.6 Шашин шүтлэг

Өмнөговь аймагт Будда, Христ гэсэн хоёр төрлийн шашны байгууллагууд бүртгэлтэй ба үйл ажиллагаа явуулдаг. Оюу Толгой төслийн зэргэлдээ орших 4 суманд явуулсан суурь судалгаанд оролцогсдын 66% нь Буддист шашин, 3.3% нь Христийн шашин шүтдэг гэсэн бол 31% нь ямар нэгэн шашин шүтдэггүй гэсэн байна (Хүснэгт 8.6-г харна уу). Христийн шашин саяхнаас нэвтэрч байгаа ч аймгийн бүх суманд тархаж, одоогоор нийт 8 суманд Христийн шашны 9 сүм үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр Христийн сүмийн үйл ажиллагааны санхүүжилтийн аравны нэг

²⁵ ОТ төслийн НЭЗБО -ны дэд судалгааны тайлан, хуудас 403.

хувийг итгэгчидийн хандиваар, бусдыг нь Монголын евангелизмын байгууллага, Дэлхийн зөн, Мөнхийн үнэн зэрэг Христийн байгууллагуудын тусламжаар бүрдүүлдэг.

Хүснэгт 8.6: Өмнөговь аймгийн хүн амын шашин шүтлэгийн байдал

Сум	Шүтлэггүй	Буддист (%)	Христос (%)	Бусад (%)
Баяндалай	34.9	63.5	1.6	-
Баян-Овоо	67.4	26.1	6.5	-
Булган	12.8	83.3	3.8	-
Гурвантэс	13.0	86.1	n/a	0.9
Мандал-Овоо	13.7	82.4	3.9	-
Манлай	26.6	73.4	-	-
Номгон	49.3	50.7	-	-
Ноён	12.2	85.4	2.4	-
Сэврэй	32.4	64.8	2.8	-
Ханбогд	11.9	86.2	1.8	-
Ханхонгор	22.9	77.1	n/a	-
Хүрмэн	33.9	64.3	1.8	-
Цогтцэций	18.3	80.0	1.7	-
Цогт-Овоо	15.2	81.8	3.0	-
Даланзадгад	20.5	73.3	5.4	0.8
Нийт аймаг	23.3	73.5	2.9	0.3

Эх сурвалж: Оюу Толгой төсөл, НЭЗБО-ны дэд судалгаа, Бодлого судлалын төв болон Хүн амын сургалт, судалгааны төв, 2009 он.

8.4.7 Боловсрол

Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засаг, байгаль орчны дэд судалгааны хүрээнд Өмнөговь аймгийн боловсролын түвшинг судалсан ба уг судалгаанд аймгийн хэмжээнд 10 болон түүнээс дээш насны нийт 4,779 иргэд оролцсоны 983 нь Оюу Толгой төслийн бүстэй зэргэлдээ орших 4 сумдын 285 өрхийн гишүүд байсан. Хүснэгт 8.7-д боловсролын түвшний судалгааны үр дүнг нэгтгэн харуулсан байна.

Хүснэгт 8.7: Судалгаанд оролцогсдын боловсролын түвшин (%)

	Боловсрол гүй	Бага	Дунд	Бүрэн дунд	Техник мэргэжлийн	Дээд	Нийт
Баян-Овоо	5.2	22.7	41.6	16.9	4.5	9.1	100
Манлай	16.8	25.5	34.1	14.1	4.1	5.5	100
Ханбогд	11.0	23.8	33.7	20.6	4.5	6.4	100
Цогтцэций	11.9	26.0	28.1	23.0	3.4	7.7	100
Төслийн нөлөөллийн бүст орших сумдын дундаж	11.2	24.5	34.4	18.6	4.1	7.2	100
Даланзадгад	5.6	15.2	22.2	28.3	10.1	18.7	100
Аймгийн дундаж	7.7	23.3	28.0	23.4	7.0	10.6	100

Эх сурвалж: Оюу Толгой төсөл, НЭЗБО-ны дэд судалгаа, 2009 оны 9 дүгээр сар

Оюу Толгой төслийн бүстэй зэргэлдээ орших Ханбогд, Баян-овоо, Манлай болон Цогтцэций гэсэн 4 сумын хүн амын 25% нь бага, 34% нь бүрэн бус дунд боловсрол, 19% нь бүрэн дунд боловсролтой. Судалгаанд хамрагдсан иргэдийн 4% нь техник мэргэжлийн, 7% нь дээд боловсролтой, харин 11% нь огт боловсролгүй иргэд байна.

Олон төрлийн албан бус сургалт, курсээр дамжуулан албан сургалтын тоог нэмэгдүүлэх мөн сургуульд хамрагдах боломжгүй иргэдэд явуулж байна. Боловсрол олгох ажлуудыг Аймгийн боловсрол, соёлын газраас 15 боловсролын төвтэй хамтран зохион байгуулж байна. Аймагт зайнаас сургах зөвлөл байгуулагдан эрүүл мэнд, англи хэл, компьютер, амьдрах ухааны сургалт, орон нутгийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн багш нарыг давтан бэлтгэх сургалт зэргийг зохион байгуулдаг. Тус аймгийн хэмжээнд ганцхан байдаг Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 12 мэргэжлээр 500 гаруй оюутан сурагч суралцаж байна.

8.4.8 Бичиг үсэг тайлагдсан байдал

Судалгаанд хамрагдсан иргэдийн 97% нь кирилл үсэгт тайлагдсан ба энэ үзүүлэлт эрчүүдийн хувьд 96%, эмэгтэйчүүдийн хувьд 98% байна.

8.5 ХАНБОГД СУМ

Ханбогд сумын нутаг дэвсгэр дээр Оюу Толгой төслийн үйл ажиллагаа явагддаг бөгөөд төслийн томоохон барилга байгууламжууд бүгд энд байрладаг.

8.5.1 Хүн ам, хүн амын өсөлт

Ханбогд сумын хүн ам 2010 онд 3,522 байсан нь өмнөх жилүүдээс өссөн (2007 онд 2,974, 2009 онд 3154 хүн амтай байв) үзүүлэлт юм²⁶. Ханбогд сумын 2007-2010 оны хүн ам, хүн ам зүйн гол мэдээллийг Хүснэгт 8.8-д үзүүлэв.

Хүснэгт 8.8: Ханбогд сумын хүн ам, 2007-2010

Гол үзүүлэлтүүд	2007	2008	2009	2010
Хүн амын тоо	2,974	3,041	3,154	3,522
Хүн амын өсөлт	-	2.3%	3.8%	11.6%
Эрэгтэй	1,441	1,474	1,562	1,753
Эмэгтэй	1,533	1,567	1,594	1,769
Хүйсийн харьцаа (эрэгтэй/ эмэгтэй)	0.94	0.94	0.98	0.99
Өрхийн тоо	839	918	985	1,112
Малчид	-	-	1,793	2,067
Малчид, хувиар	-	-	56.8%	58.7%
Сумын төвийн оршин суугчид	-	-	1,363	1,455
Өрхийн гишүүдийн дундаж тоо	3.54	3.31	3.26	3.17

Эх сурвалж: Ханбогд сумын хүн амын мэдээллийн сан, 2011 он. Сумын Статистикийн Газар

Хүснэгт 8.9: Хүн амыг харьяалагдах багаар нь үзүүлбэл:

²⁶ 2011 оны хүн амын тооллогоор баталгаажуулсан

Хүснэгт 8.9: Хүн ам багийн зохион байгуулалтад хуваагдсан байдал

	Жавхланта		Номгон		Гавилууд		Баян		Сум	
	Хүн ам	Айл өрх	Хүн ам	Айл өрх	Хүн ам	Айл өрх	Хүн ам	Айл өрх	Хүн ам	Айл өрх
2007									2,974	839
2008									3,041	918
2009	944	285	544	205	928	264	740	231	3,156	985
2010	997	315	693	227	1012	308	820	262	3,522	1,112

Эх сурвалж: Статистикийн Газар. Ханбогд сумын Засаг даргын Тамгын газар

2010 оны байдлаар сумын нийт хүн амын 40% буюу 1,455²⁷ нь сумын төвд амьдарч байна (үлдсэн 60% нь сумын хөдөө амьдардаг). 2010 оны байдлаар Ханбогд суманд 2,067 малчин²⁸ амьдарч байсан ба сумын хүн амын гуравны хоёрыг эзэлж, хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй байв²⁹. Сумын иргэдийн ихэнхи нь хөдөө орон нутагт амьдардаг бөгөөд зарим малчин айл сумын төвд байрлаж бусад гэрээт малчдаар малаа маллуулдаг байна (Бүлэг В9-д дэлгэрэнгүй бичсэн).

Тус суманд өрхийн гишүүдийн тоо эрс буурч байгаа. Тухайлбал, 2000 онд сумын 1 өрхөд дунджаар 4 хүн ноогдож байсан бол энэ үзүүлэлт 2007 он гэхэд 3.5, 2010 онд 3.1 болтлоо буурчээ. Улсын хэмжээнд болон аймгийн хэмжээнд ижил байгаа энэ хандлагын талаар өмнө нь өгүүлсэн³⁰.

Ханбогд сумын малчин өрхийн тоо 2007-оос 2010 оны хооронд жил бүр нэмэгдсээр иржээ. Хүснэгт 8.10-г харна уу.

Жил бүр сумын оршин суугчдын бүртгэлийг шинэчилдэг ба энэ тооллогыг голдуу өвлийн улиралд хийдэг. Малчин хэмээн бүртгэлд хамрагдсан иргэд голдуу хөдөө орон нутагт амьдардаг ч заримдаа сумын төвд оршин суудаг. Харин хувийн малтай хэдий ч сумын төвд оршин сууж, малчин өрх хэмээх ангилалд ордоггүй иргэд мөн байдаг.

Хүснэгт 8.10: Орон нутгийн малчдын тоо ба Ханбогд сумын төвийн оршин суугчид, 2007-2010³¹

Ханбогд сум	2007			2008			2009			2010		
	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм
Хүн ам	2,974	1,441	1,533	3,041	1,474	1,567	3,156	1,562	1,594	3,522	1,753	1,769
Хөдөөгийн малчин							1,793	887	906	2,067	1,015	1,052

²⁷ Олон улсын хүнс, ХАА-н байгууллага, Оюу Толгойн Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын нөлөөллийн үнэлгээ, хөдөөгийн ядуурлыг бууруулах нь, 2011 он

²⁸ Сумын статистикийн хэлтэс

²⁹ Ханбогд сумын тамгын газар: Статистикийн Хэлтэс, 2011 он

³⁰ Хөдөө орон нутгийн хүн амын тоог нарийн гаргахад хүндрэлтэй байсан учир нь хөдөөгийн малчин иргэдийн 20 гаруй хувь нь өвлийн улиралд сумын төвд оршин сууж, зуны улиралд малаа даган нүүдэллэдэгтэй холбоотой. ОУХХААБ, 2010 он

³¹ 2009 оноос өмнө нарийвчилсан мэдээлэл байгаагүй, тухайлбал орон нутгийн малчид болон төвийн суурин иргэд

Ханбогд сум	2007			2008			2009			2010		
Сумын төвд							1,363	675	688	1,455	738	717

Эх сурвалж: Ханбогд сум, Өмнөговь аймгийн Статистикийн Хэлтэс, 2011 он.

Сумын төвийн хүн амын 40% нь улирлаар нүүдэллэдэг малчид³² бөгөөд бэлчээрийн сайныг дагаж өвөл зуны улиралд тэмээ, адуу, ямаа, хонь зэрэг малаа маллан нүүлэг 33. Сүүлийн жилүүдэд гэрээ нүүлгэлгүйгээр ойр орчимдоо малаа бэлчээрлүүлдэг суурин малчид олширч байгаа. Мөн малчид сумын төвд байнга оршин сууж, суурьшмал амьдралын хэв маягт ихээр шилжиж байна. Зун намрын саруудад малчид бэлчээрийн сайныг хайж нүүдэллэн, зундаа гэрийнхээ ойролцоох гар худгаар малаа услан, усны хэрэгцээг хангадаг. Ихэнх малчин гэр бүлүүд өөрсдөө нүүдэллэн амьдарч, үр хүүхдээ сумын төвд байдаг хамаатнуудындаа суулган сургуульд сургадаг болжээ. Малчдын аж амьдралын талаар энэхүү тайлангийн Бүлэг В9: Хөдөлмөр Эрхлэлт Ба Амьжиргааны Түвшин бүлэгт дэлгэрэнгүй өгүүлсэн.

8.5.2 Ирэх болон явах шилжих хөдөлгөөн

Саяхныг хүртэл Ханбогд сум нь Монгол улсын бусад сумдын адил хүн амын тоо нь буурч байсан бөгөөд нутгийн иргэд нь Улаанбаатар хот руу нүүж байсан. 1997 оноос 2003 оны хооронд ганц жилээс бусад бүх хугацаанд Ханбогд сумаас нүүж явах иргэдийн тоо шилжин ирэгсдээс ямагт илүү байв. 2004 оноос хойш Оюу Толгой дээр үйл ажиллагаа нэмэгдснээс үүдэн энэхүү харьцаанд явагсдын хувь багассан ба 2006³⁴ оноос ирэгсдийн эзлэх хувь их хэмжээгээр нэмэгдсэн байна. Энэхүү шилжилт хөдөлгөөн нь Ханбогд сумын өсөлтөнд нөлөөлсөн бөгөөд 2007-2010 оны хооронд 18% - ийн өсөлттэй байсан ба хүн ам нь 2,974-ээс 3,522 хүрсэн байна.

Хүснэгт 8.11: Ханбогд сумд шилжин ирэгсэд болон сумаас нүүгчид мөн цэвэр шилжилт хөдөлгөөн, 1997-2006

Он	Шилжин ирэгсэд	Шилжин нүүгчид	Цэвэр өөрчлөлт
1997	31	40	-9
1998	8	18	-10
1999	23	27	-4
2000	22	20	2
2001	33	59	-26
2002	36	42	-6
2003	10	23	-13
2004	68	6	62
2005	60	9	51
2006	230	43	187

Эх сурвалж: Ханбогд сумын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын статистикийн газар, Оюу Толгойн Шилжих хөдөлгөөний эрсдлийн үнэлгээ, 2007 он

³² Нүүдэллэдэг малчдын тодорхойлолтыг В10 –р Бүлгээс харна уу

³³ Бүлэг В10-аас улирлаар нүүдэллэдэг хөдөөгийн малчдын талаар дэлгэрэнгүй харна уу.

³⁴ Ханбогд сумын хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн хамгааллын төвийн статистик, Барклейд хэвлэгдсэн Оюу Толгойн Шилжилт хөдөлгөөний нөлөөллийн үнэлгээ, 2011 он

Ханбогд сумд шилжин ирэгсдийн дийлэнх нь орон нутгаас байсан ба гуравны нэг нь орон нутагт хамаатан төрөл төрөгсдийн холбоотой байсан байна. Ханбогд сумд шилжин ирэгсдэд хийсэн судалгаагаар 2006 оны байдлаар дөрөвний гурав буюу 77% нь Өмнөговь аймгаас, 9% нь зэргэлдээх аймгуудаас, харин 7% нь Улаанбаатар хотоос ирсэн байна³⁵. Ханбогд сумд шилжин ирэгсэд суурьшсан бөгөөд гуравны нэг буюу 36% нь тус суманд гэр бүлтэй эсвэл хамаатан, төрөл төрөгсөтэй байв. 2008 оны суурь судалгаагаар Ханбогд сумын нийт айл өрхийн 7% нь өөр бусад газраас шилжин ирсэн мэдээлэл байна.

Оюу Толгой нь 2007 онд Шилжих хөдөлгөөний эрсдлийн үнэлгээг хийсэн ба энэ нь төсөлтэй холбоотой барилгын шатан дахь шилжин ирэгсдийн тоог гаргах зорилготой байв³⁶. Энэхүү судалгаагаар 2010 он гэхэд Оюу Толгой төслийн ойр орчимд 500-1700 шилжин ирэгсэд хамгийн багадаа богино хугацаагаар суурьшихаар тооцоо гарсан бөгөөд судалгаа нь уурхай болон бусад тлнлг төхөөрөмж дээр ажиллах 1700 Монголын ажилчдын тооцоон дээр үндэслэсэн байна. Ажиллах хүчний тоо тооцоолсноос харьцангуй хурдан өссөн байна. 2011 оны 12-р сард барилгын шатны ажиллах хүчний хамгийн өндөр нь 17,904 байсны 11,722 нь Монгол ажилчид байсан байна.

Эрүүл мэндийн нөлөөлөл үнэлгээний³⁷ судалгаагаар аймгийн төв Даланзадгад, Ханбогд сум нар нь төслийн үйл явц болоод барилгын шатны үйл ажиллагаанаас хамаарч шилжин ирэх хөдөлгөөнөөс үүдэн хүн амын тоо нэмэгдсэн байна. Нөлөөлөлд өртсөн Ханбогд сумтай хил залгаа Баян-Овоо болон Манлай 2 сумын хувьд аль аль чиглэлд иргэдийн шилжих хөдөлгөөн байсаар байна (Ханбогд сум руу уурхайтай холбоотой ажил хайн нүүх болон бусад газраас ажил хайн шилжин ирэх).

Эрүүл мэндийн нөлөөллийн судалгаагаар ханбогд сумыг оролцуулан эдгээр 4-н нөлөөллийн бус нутагт хүн амын нягтшил судын төвүүдэд малчин айл өрхүүд нүүн ирж байгаатай холбоотой нэмэгдсээр байна. Нөлөөлж байгаа хүчин зүйлс нь:

- Бэлчээрийн газрын доройтол болон талхлагдал;
- Өвлийн эрс тэс байдал
- Уламжлалт мал аж ахуйгаас цалин хөлстэй ажилд шилжих
- Дэлхий даяарх санхүүгийн хамралын дараах мал аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний зах зээлийн сэргэлт удаан болон улирлын хүнд нөхцөл байдал

Энэхүү нөхцөл байдал нь малчдыг улам бүр Оюу Толгой болон бусад аж ахуйн нэгжид ажил хайхыг эрчимжүүлсэн байна.

Саяхны Ханбогд сумд шилжин ирэгсдийн тоон мэдээлэл

Сүүлийн жилүүдэд Ханбогд сумд шилжин ирсэгсдийн тоо баримтыг доор харуулав (Оюу Толгойн гэрээт гүйцэтгэгчид болон сумын төвд амьдардаг ажилчдыг оруулсан боловч уурхайн лицензтэй талбай дахь барилгын каймп болон бусад каймпуудад амьдарч байгаа ажилчдыг оруулаагүй болно):

Хүснэгт 8.12: Ханбогд сумын төвийн хүн ам болон шилжилт хөдөлгөөн

Он	Сумын төвийн хүн ам	Шилжин ирэгсэд	Шилжин нүүгчид	Цэвэр шилжилт	Шилжилтийн өсөлтийн хувь
2006	2901	183	33	150	5.2%
2007	2974	126	72	54	1.8%
2008	3022	71	68	3	0.1%
2009	3154	96	50	46	1.5%

³⁵ Барклейд хэвлэгдсэн Оюу Толгойн Шилжилт хөдөлгөөний нөлөөллийн үнэлгээ, 2007 он

³⁶ Барклейд хэвлэгдсэн Оюу Толгойн Шилжилт хөдөлгөөний нөлөөллийн үнэлгээ, 2007 он

³⁷ Оюу Толгойн Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдлын нөлөөллийн үнэлгээ, 2011 он

Он	Сумын төвийн хүн ам	Шилжин ирэгсэд	Шилжин нүүгчид	Цэвэр шилжилт	Шилжилтийн өсөлтийн хувь
2010	3522	305	49	256	7.3%
2011 (10-р сар хүртэл)	3900 ойролцоогоор	323	86	237	7.3% (жилд шилжүүлсэн)

Эх сурвалж: Ханбогд сумын ЗДТГ

Бүх Ханбогд сумд шилжин ирэгсэд нь сумын захиргаанд бүртгүүлэх шаарлагатай байдаг (Монгол улс даяар). Эдгээрт байнгын болон түр хугацааны Монгол доторх шилжилт мөн үндэсний болон олон улсын гэрээт гүйцэтгэгчид хамаарна. Үүнээс үүдэн дээрх хүснэгтийг гаргасан ба энэ нь олон янзын шалтгаанаар сумын төвд шилжин ирсэн иргэдийг бүртгэсэн байна.

8.5.3 Хүйсийн харьцаа

Сумын төв болон хөдөөгийн малчин иргэдийн дунд хүйсийн харьцаа бараг ижил түвшинд байна. Сумын 5 өрх тутмын нэгийг эмэгтэйчүүд толгойлсон байгаа нь (18.3%)³⁸ эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын ялгаанаас (эмэгтэй 71.0, эрэгтэй 63.7 нас) болон эрчүүд Улаанбаатар, Эрдэнэт зэрэг томоохон суурин газруудад ажил хөдөлмөр эрхлэхээр явдаг зэргээс шалтгаалсан байх талтай. 8.10 –р хүснэгтэнд харуулсанчлан эрэгтэйчүүдийн хүн амд эзлэх тоо нь эмэгтэйчүүдийн өсөлттэй харьцуулахад бага зэрэг илүү хурдан нэмэгдэж байгаа нь уул уурхайн салбарын ажил эрхлэлттэй холбоотой юм (Оюу Толгойн ажил эрхлэлттэй холбоотой Ханбогд сумын хувьд мөн адил)³⁹. Статистикийн мэдээнээс харахад эрчүүдийн хүн амд эзлэх тоо эмэгтэйчүүдийнхээс илүү хурдан өсч байгаа нь уул уурхайн салбар хөгжиж шилжин суурьшилт ихэссэнтэй холбоотой (ОТ төслийн хүрээнд).

8.5.4 Угсаатан

Ханбогд сумын иргэдийн дийлэнх нь халх монгол иргэд байна.

8.5.5 Хэл

Ханбогд сумын иргэд халх монгол хэлээр ярьдаг.

8.5.6 Шашин шүтлэг

Ханбогд сум нь шашин шүтдэг иргэдийн хүн амд эзлэх хувиараа аймагтаа тэргүүлдэг. Суурь судалгаанд хамрагдсан иргэдийн ихэнх буюу 86% нь буддист шашныг, 2% нь христийн шашныг тус тус шүтдэг гэсэн бол 12% нь шашин шүтдэггүй гэж хариулсан байна.

8.5.7 Боловсрол

Уламжлалт ёсны дагуу бол нүүдэлчин малчин иргэдийн хүүхдүүд 2-3 настайдаа улирлын нэр, газрын чиг баримжаа, чиглэл, нүүдэл хийх газар орны нэр зэргийг цээжлэх зэргээр оюун ухаанаа хөгжүүлж эхэлдэг байжээ. Нүүдэлчин малчдын хүүхдүүд малын өнгө зүс, малын үүлдэр, зэрлэг ан амьтдыг мөрдөх, алсаас тоолох, цаг агаар шинжих зэрэг аргуудад суралцдаг. Уул, газар усны нэр тогтоох зэрэгт ч бас суралцдаг. Харин одоо үед хүүхдүүд албан ёсны системийн дагуу боловсрол эзэмших болсон.

Ханбогд суманд 2007-2008⁴⁰ оны хичээлийн жилд бага ангид 360 хүүхэд 11 багштайгаар, дунд ангид 258 хүүхэд 10 багштайгаар, ахлах ангид 77 сурагч 9 багштайгаар тус тус хичээллэсэн байна. Хүн амын өсөлттэй холбоотойгоор боловсролын байгууламж хүрэлцэхгүй болсноос сургуулийн

³⁸ Ханбогд сумын хүн амын мэдээллийн сан, 2011 он

³⁹ АХБ-ы 2009 онд гаргасан хүн амын огцом шилжих хөдөлгөөний талаарх урьдчилсан тооцоо ба эхний шатанд Өмнийн говийн бүс нутаг дахь эдийн засгийн шинэ хөгжлөөс үүдэн нэмэгдэх эрэгтэйчүүдийг оруулсан байна. Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, Монгол улс: Зүүн өмнийн говийн хотын болон хил орчмын хотын хөгжлийн төсөл ба Хөрөнгө оруулалт болон төрийн сангуудын зохион байгуулалт, удирдлагыг үр дүнг сайжруулахад менежментийг нэвтрүүлэх, 2009 оны 11-р сар.

⁴⁰ Ханбогд сумын хүн амын мэдээллийн сан, 2011

өмнөх насны боловсрол олгох цэцэрлэгийг орхих хүүхдийн тоо өсч, сургуулиудын даац хэтэрчээ. 360 хүүхэд суралцах багтаамжтай сургуульд 700 хүүхэд суралцаж байна. Иймээс Оюу Толгой компани нь Орон нутгийн болон бүс нутгийн төлөвлөлт, дэд бүтцийн хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн цэцэрлэгийг өргөтгөх ажилд туслахаар төлөвлөж байна. (Бүлэг С8: Хүн ам ба төвлөрөл-г үзнэ үү)

Ханбогд суманд бага ангийн элсэлтийн түвшин аймгийн дунджаас дээгүүр байдаг боловч 12 наснаас дээш ангиудад элсэлтийн түвшин аймгийн дунджаас доогуур болж буурдаг болохыг ОТ төслийн суурь судалгаагаар⁴¹ тодорхойлсон байна. Харин эмэгтэй сурагчдийн элсэлтийн түвшин Даланзадгадаас бусад сумтай харьцуулахад өндөр байна. Мөн 7-15 насны сургууль завсардсан хүүхдийн тоо Ханбогд суманд төслийн зэргэлдээ орших бусад сумтай харьцуулахад өндөр байгаа юм. Сургууль завсардсан хүүхдүүдийн нэгээс бусад нь малчин өрхийн хүүхдүүд байна.

8.5.8 Бичиг үсэгт тайлагдсан байдал

Ханбогд сумын иргэдийн 98% нь бичиг үсэг бүрэн тайлагдсан ба 28% нь хуучин монгол бичиг, 53% нь Латин үсэгт тайлагдсан байна.

8.6 ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖИЛ

Олон нийттэй харилцах, тогтвортой хөгжлийн хэлтэс нь одоо хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийнхээ хүрээнд Ханбогд сумын хүн амын мэдээллийн санг шинэчлэх, орчуулах ажлыг хийсээр байгаа юм. ОНХТХХ нь хүн ам зүй, боловсролын түвшин, орон байр, бусад нийгмийн дэд бүтцийн хэрэгцээ зэрэг чиглэлүүдээр мэдээллийг ОНХТХХ-ийн тогтмол судалгаанууд болон 2010 оны Улсын хүн амын тооллогын дүнд дүн шинжилгээ хийж үзнэ. Сумын түвшний нийгэм эдийн засгийн мэдээ, тоо баримтуудыг Оюу Толгой ХХК-ний ОНХТХХ болон бусад группүүд байнга цуглуулсаар байх болно.

⁴¹ Тусгай бүлгийн уулзалт, хагас боловсруулсан асуулга, ярилцлага зэрэгт тулгуурласан судалгаа.

Орчуулгын үнэн зөвд баталгаа гаргахаас татгалзах тухай

Оюутолгой төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг англи хэл дээр боловсруулж, монгол хэл рүү орчуулав.

Оюутолгой ХХК уг үнэлгээг монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, англи болон монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг уншина уу.

Оюутолгой ХХК нь орчуулгын үнэн зөв, бүрэн төгс байдлын талаар ямар нэг баталгаа гаргахгүй бөгөөд Оюутолгой ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа (Гэрээ, хэлцэл, гэм хорын дагуу буюу холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүссэн г.м) хохирлыг хариуцахгүй болно.

Та уг орчуулгын алдаа, дутагдал болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө OTESIA@ot.mn хаягаар ирүүлнэ үү.